



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 117

Номгон

Баян-Овоо сумын Дашгэмпэллин хийдийн
дүрмийг баталж, үйл ажиллагааны
зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Дашгэмпэллин хийдийн дүрмийг хавсралтаар шинэчлэн баталж, үйл ажиллагааны зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгасугай.

2. Дашгэмпэллин хийдийн улсын бүртгэлийн зөвшөөрлийг шинэчлүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг хийдийн тэргүүн лам /О.Жаргалсайхан/-д зөвлөсүгэй.


3. Дашгэмпэллин хийдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөл /Э.Цэнд/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын
13-ны өдрийн 117 дугаар тогтоолын хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ДАШГЭНПЭЛЛИН ХИЙДИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хийд нь Монгол Улсын хууль, Иргэний хууль, төрийн бус байгууллагын тухай хууль, Төр, сүм, хийдийн харилцааны тухай хууль, тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

1.2. Үүсгэн байгуулагчаас шашны байгууллагыг байгуулах тухай шийдвэр гаргаж, дүрмийг баталснаар байгуулагдсанд тооцно.

Хоёр. Оноосон нэр, байршил

2.1. Оноосон нэр: Дашгэнпэллин хийд. Монголоор Өлзий Буян дэлгэрүүлэх хийд

2.2. Хаяг: Баянхонгор аймаг Баян-Овоо сум 4 дүгээр баг.

Харилцах утас: 99085169, 88189819

Гурав. Үйл ажиллагааны зорилго, чиглэл

3.1. Хийд нь ашгийн бус, нийгэмд үйлчлэх шарын шашны зан үйлийн ёс жаяг, дэгийг өвлүүлэх, хүүхэд, залуучууд, нийт сүсэгтний дунд бурхан, шашны номыг түгээн дэлгэрүүлэхийг эрхэм болгоно.

3.2. Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхдээ дараах үйл ажиллагааг явуулна.

3.2.1. Уламжлалт шашны зан үйл болон ёс жаягийг өвлүүлэх зорилгоор лам, санваартан сургаж, шавилуулах

3.2.2. Бурхны номд суралцах ба судлах сонирхолтой хүүхэд, залуучуудад туслах зорилгоор сургалт зохион байгуулах болон бусад олон талт арга хэмжээг зохион явуулах

3.2.3. Ард иргэдийн шашны мэдлэгийг тэлэх болон суралцагчдын сургалтад зориулж гарын авлага, товхимол, ном, бүтээлийг судалгаанд үндэслэн хэвлэн нийтлэх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах

Дөрөв. Хийдийн бүтэц, хяналтын тогтолцоо

4.1. Хийдийн эрх барих байгууллага нь удирдах зөвлөл байна

4.2. Удирдах зөвлөлийн гишүүнийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр сонгож батлах ба 5 гишүүнээс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн дарга нь тэргүүн лам байна.

4.3. Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.3.1. Хийдийн тэргүүн ламыг сонгох

4.3.2. Хийдийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

4.3.3. Хийдийг өөрчлөн байгуулах

4.3.4. Хийдийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар шийдвэр гаргах

4.3.5. Хийдийн бүтэц зохион байгуулалт, түүний төсвийг батлах

4.3.6. Хийдийн хурлын үйл ажиллагаа ба санхүүгийн зарцуулалтад хяналт

тавих

4.4. Тэргүүн лам хийдийг гадаад, дотоодод төлөөлөх, удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах болон хууль, гэрээнд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.5. Удирдах зөвлөлийн дарга, гишүүнээс сайн дураар чөлөөлөгдөх хүсэлтээ удирдах зөвлөлийн хуралд оруулж, гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4.6. Удирдах зөвлөлийн даргыг дараах үндэслэлээр чөлөөлнө.

-Нас барсан

-Зөвлөлийн гишүүнийхээ үүргийг зохих ёсоор биелүүлээгүй

-Монгол Улсын хууль тогтоомж, хийдийн дүрмийг удаа дараа болон ноцтой зөрчсөн

4.7. Удирдах зөвлөлийн гишүүд хамтын шийдвэр гаргах бөгөөд бүрэн эрхээ хурлаар хэрэгжүүлнэ.

4.8. Удирдах зөвлөлийн хурлыг удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр буюу удирдах зөвлөлийн 2-оос доошгүй гишүүний хүсэлтээр зарлан хуралдуулна.

4.9. Удирдах зөвлөлийн гишүүдийн 2/3 хувь хуралд оролцсоноор хуралдааны ирцийг хүчинтэйд тооцно.

4.10. Удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол байх ба тогтоолд удирдах зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.11. Удирдах зөвлөлийн хурал хийсэн тухай бүр хурлын тэмдэглэл хөтөлнө.

4.12. Удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбарыг хурлын тэмдэглэлд хавсаргана.

4.13. Удирдах зөвлөл нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураалтаар шийдвэрлэнэ.

Тав. Хийдийг өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл

5.1. Хийдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуульд заасан журмын дагуу өөрчлөн байгуулж болно.

5.2.Хийдийг татан буулгасан тохиолдолд хийдийн эд хөрөнгө болон шашны эд зүйлийг ижил төрлийн байгууллага болон шашны төвд өргөнө.

5.3.Хийдийг дараах үндэслэлээр татан буулгана

-Эрх бүхий байгууллагын шийдвэрээр

-Хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах шүүхийн шийдвэр гарсан

6.1.Хийдийн дүрэмд нэмэлт, өөрчлөлтийг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.2.Хийд нь дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг аймгийн ИТХ-д тухай бүр албан ёсоор мэдэгдэнэ.

Долоо.Хийдийн санхүүжилт

7.1.Хийдийг сүсэгтний хандив,туслалцаагаар бүтээн босгосон бөгөөд өвлүүлэх, хувь эзэмших, ашиг харах зэргээр өөрсдийн амьдралд ашиглаж, зарцуулахгүй цэвэр шашны өмч болно.

7.2.Хийдийн орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

-Сүсэгтэн олон, аж ахуйн нэгж байгууллагын хандив

-Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон дурын үндсэн орлого

-Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсөв болон бусад байгууллагаас олгосон хөрөнгө

7.3.Ашгийн бус үйл ажиллагаанаас хуримтлагдсан мөнгө, хөрөнгөөс лам, ажилчдыг цалинжуулах хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшил олгох, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд лам, санваартанг сайн дурын үндсэн дээр хамруулна

7.4.Хийд нь өөрийн өмчлөлд байгаа эд хөрөнгөөр үүрэг хүлээнэ

7.5.Санхүүгийн бүртгэл, тайлан тооцоог Монгол Улсын хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан бусад актуудын дагуу хөтөлнө.



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 118

Номгон

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн Л.Доржхандыг оруулсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан 2018 оны 70 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

